

МӨНГӨН УСНААС ТАТГАЛЗЪЯ



planet**GOLD**
Mongolia

Монгол дахь бичил уурхайн нөхцөл байдал ямар түвшинд байгаа вэ?



Монгол Улсын Засгийн газар 2010 онд бичил уурхайн талаар журам гаргаж, хуулийн хүрээнд зохицуулах алхам хийсэн. Одоогоор 2017 оны 151-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” нь эрх

зүйн үндсэн акт болж байна.

Манай улсад нийт 14 аймаг¹ 40,000-60,000² хүн бичил уурхайгаар буюу гар аргаар алт олборлож байна гэсэн тооцоо бий..

Алттай чулууг хэрхэн баяжуулдаг вэ?

Бичил уурхайчид алтны үндсэн ордын чулуулгийг ихэвчлэн далд (цооног, хонгил үүсгэн) аргаар олборлодог. Алттай хүдрийг газрын гүнээс гаргаж, баяжуулах цех рүү тээвэрлэнэ. Маш жижиг хэмжээтэй алтыг үндсэн чулуулгаас нь салгахын тулд буталж нунтагладаг. Түүний дараа хүдрийн шинж чанараас хамаарч хүндийн хүч (гравитаци), уусгалт (гидрометаллурги), хөвүүлэлтийн (флотаци) үндсэн баяжуулах аргуудаас ашиглаж, алтны нарийн тоосонцор ширхгийг ялгах боломжтой. Харин манай улсад бичил уурхайчид нэг бол хувиараа албан бусаар эсвэл гар аргаар алтаа ялгадаг, аль эсвэл алтны бичил уурхай түшиглэсэн баяжуулах цехүүдэд уламжлалт хүндийн хүчний аргаар алтаа ялгаж авдаг. Хүндийн хүчний аргаар баяжуулсан хүдрийн хаягдалд алт ихээр үлддэг учраас цианидын уусгалтаар баяжуулдаг гуравдагч үйлдвэрт гүйцээн баяжуулах явдал байсаар байна.

¹ Ашигт малтмал, газрын тосны газар

² ШХА, Тогтвортой бичил уурхай төсөл

Мөнгөн ус гэж юу вэ?



Мөнгөлөг өнгөтэй, шингэн төлөв байдалд оршдог **мөнгөн ус нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд маш хортой хүнд металл юм.** Мөнгөн ус нь

задардаггүй, устдаггүй тул удаан хугацаанд хор нөлөө үзүүлсээр байдаг.

Мөнгөн усыг алтны хүдэр баяжуулахад ашигладаг боловч алтыг бүрэн гүйцэд ялгаж чаддаггүй. Алт, мөнгөн усны нэгдлийг амальгам гэж нэрлэдэг. Алт олборлогчид алтыг мөнгөн усаар амальгамжуулан нэгдүүлж, түүнийгээ шахаж, ууршуулж, хайлуулж шатаах зэргээр алтыг хагас цэвэршүүлэх явцад өөрсдийгөө болон хүрээлэн буй орчноо хордуулж байдаг.



Хүмүүс мөнгөн усанд хэрхэн өртдөг вэ?

Мөнгөн ус нь тасалгааны хэмд амархан ууршдаг. Агаарт ууршсан мөнгөн ус нь өнгө, үнэргүй бөгөөд маш хортой, наалдамхай чанартай байдаг. Тиймээс амальгамыг шатаах явцад агаарт ууршсан мөнгөн усаар амьсгалах нь эрүүл мэндэд хамгийн аюултай. **Амьсгалаар орсон мөнгөн усны 80 орчим хувь нь уушгинд үлдэж, цусны эргэлтэд ордог.** Мөн биеийн арьс, хувцас эдлэл, тавилга, ажлын багаж хэрэгсэл, хана зэрэгт шингэсэн тохиолдолд удаан хугацааны туршид өндөр агууламжтай мөнгөн ус ялгарсаар байдаг.¹²

¹ Алтны бичил уурхайд хэрэглэгддэг химийн бодисын хор хөнөөл. АБУЗ 2020


² Гэрэл зургуудыг Алтны бичил уурхайн зөвлөл


МӨНГӨН УСНЫ ХҮНИЙ БИЕД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ




Биед шингэх





Сөрөг нөлөөлөл



 Агаарт ууршсан металл мөнгөн
 усаар амьсгалах
 (биед шингэх хувь ~ 80%)



 Органик мөнгөн ус бүхий
 хүнс хэрэглэх
 (биед шингэх хувь ~95%)


-  Металл мөнгөн усны
/цочмог хордлого/
-  Металл мөнгөн усны
/архаг хордлого/
-  Органик мөнгөн усны
/архаг хордлого/



Тархи
 Салганах, ой санамжаа алдах, алхахад
 бэрхшээлтэй болох, цухалдуу болох,
 нойрны эмгэг үүсэх


Ам
 Ам, уруул, буйлны үрэвсэл


Уушги
 Амьсгал олшрох, цээж хөндүүрлэх,
 уушги устах


Зүрх
 Зүрх судасны өвчлөлүүд


Гэдэс дотор
 Дотор муухайрах, бөөлжих


Бөөр
 Бөөрний үйл ажиллагаа доголдох

© AGC 2020


ОРОН НУТАГТ НЭВТРҮҮЛЭХ МӨНГӨН УСГҮЙ ХҮДЭР БАЯЖУУЛАХ ЦЕХ ЯМАР ДАВУУ ТАЛТАЙ ВЭ?

- Монгол Улс тогтоомжид нийцсэн албан ёсны зөвшөөрөлтэй
- Албан ёсны зөвшөөрөлтэй бичил уурхайн талбайгаас уг талбайд бүртгэлтэй нөхөрлөлүүдийн олборлосон алтны хүдрийг хүлээн авдаг
- Мөнгөн усны болзошгүй хэрэглээнээс сэргийлнэ
- Хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаална
- Байгаль орчны хариуцлагатай удирдлага хэрэгжүүлнэ
- Усны хариуцлагатай хэрэглээтэй байна
- Орон нутгийн онцлогт тохирсон баяжуулах технологи ашиглаж, алт барилтыг дээшлүүлнэ
- Бичил уурхайчид алтаа албан ёсны нийлүүлэлтийг сүлжээгээр дамжуулан худалдана
- Алтны үнэ тогтвортой байна
- Бичил уурхайчдын орлого дээшилж, ажлын байр бий болно.

АЛТ БАЯЖУУЛАХ ЦЕХ



БАЯЖУУЛАХ ЦЕХЭД АШИГЛАХ ТӨХӨӨРӨМЖҮҮД



БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

Албажуулалт



Алтны бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн бодлого журам, арга хэрэгслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын ажилтнууд болон бичил уурхайчдыг чадавхжуулна.

Санхүүгийн хүртээмж



Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулахад хувь нэмэр оруулж, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн сан байгуулан, бичил уурхайчдыг хөрөнгө оруулагчидтай холбоно.

Технологи сайжруулах



Мөнгөн усгүй, байгаль орчинд нөлөө багатай аргаар алтны хүдэр боловсруулах технологийг туршин нэвтрүүлж, олборлолт, баяжуулалтын арга технологи, байгаль орчны удирдлага, жендэрийн тэгш байдлын талаарх сайн туршлагыг түгээж, чадавхыг бий болгоно.

Мэдлэг, мэдээлэл түгээх




Олон нийтийн платформ, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан бичил уурхайн салбарын оролцогч талуудад мэдлэг, мэдээлэл түгээж, бичил уурхайн ололт амжилт, сайн туршлагыг үндэсний болон олон улсын түвшинд сурталчлан таниулна.



Монгол Улс Мөнгөн усны тухай Минаматагийн Конвенцод нэгдэн орж улмаар 2015 онд соёрхон баталсан. Даян дэлхийн байгаль орчны сангаас тус конвенцод нэгдсэн орнуудад дэмжлэг үзүүлэхээр planet-GOLD “Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр” төслийг 8 улсад санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. planet-GOLD Монгол төслийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага хэрэгжүүлж, БОАЖЯ, Канад Улсын Алтны бичил уурхайн зөвлөл гүйцэтгэж байна.

Төслийг хэрэгжүүлэх бүс нутаг: Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ.

Бидэнтэй холбогдож манай төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, хамтран ажиллахыг урьж байна

 Хүннүгийн гудамж-906, Их Монгол оффис, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Улаанбаатар хот, 13311

 +976 77225588, 77559695

 npm.mn@artisanalgold.org

 pGOLDmongolia

 planetGOLD_MN

 planetGOLD.org

 artisanalgold.org



Санхүүжүүлэгч



Үндсэн хэрэгжүүлэгч



Хамтран хэрэгжүүлэгч:

